Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)





Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
http://orientalstudies.ru
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXIX • 2026 • № 3

Выходит 4 раза в год
Издается с 1986 г.
Учредитель: ФГБУН
Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор, доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат филологических наук (Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря, кандидат исторических наук (Россия)*

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук (Монголия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Ц. Саранцацрал, *доктор филологических наук (Монголия)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева
Литературные редакторы и корректоры – И. В. Кульганек, Д. А. Носов
Технический редактор – М. А. Козинцев
Подписано в печать 15.09.2026
Формат 60×90 $^{1}/_{8}$. Объем 10 печ. л. Заказ №
Тираж 300 экз.
Отпечатано в типографии ООО «Литография Принт».
Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8, лит. А, офис 14.
e-mail: info@litobook.ru

ISSN 2311-5939

DOI

12+

© Институт восточных рукописей РАН (Азиатский Музей), 2026
© Коллектив авторов, 2026

В НОМЕРЕ:

К 60-летнему юбилею венгерского монголоведа Агнеш Бирталан 5

ФИЛОЛОГИЯ

И. А. Алимов. «Дун цзин мэн хуа лу»: Ночной рынок 8

С. Мөнхсайхан. Дундад үеийн монгол хэлний гийгүүлэгч авианы зарим онцлог 14

В. З. Церенов. Горы Богдо в Прикаспийской низменности (варианты одной легенды) 21

ИСТОРИОГРАФИЯ

Э. Гансүх. "Хошуу Наадам" Зургийн Хурдан Морины Шинжийг Судрын Шинжтэй Харьцуулсан Судалгаа 26

СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ

А. М. Мокеев, К. Белек. Н. Абдимиталип уулу. Истоки философии сострадания Асана Кайгы 37

М. В. Фионин. Рукописный перевод М. М. Елизаровой «Завещания Авраама»: текстологическая база и переводческая стратегия 47

НАУЧНАЯ ЖИЗНЬ

М. А. Козинцев, И. В. Кульганек. VI Международная научная конференция «Тюрко-монгольский мир в прошлом и настоящем» (Санкт-Петербург, 16 марта 2026 г.) 64

ПЕРЕВОДЫ

Р. В. Ивлева. *Сэнгийн Эрдэнэ*. Дзанабадзар (перевод с монгольского, примечания) 71

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXIX • 2026 • No. 3

The journal is published four times a year.
Published since 1986
Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*
D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*
M. A. Kozintcev — *assistant secretary, Cand. Sci. (History), Russian Federation*

G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*
A. Birtalan. *Ph. D., Hungary*
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*
L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
J. Legrand. *Dr. Sci., Professor, France*
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*
E. E. Khabunova, *Dr. Sci. (Philology), Russian Federation*
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*
E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*
S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*
R. Pop. *Ph. D., Romania*
Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*
T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*
R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*
N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*
I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

191181. Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18

Phone: +7 (812) 315-87-28
http://orientalstudies.ru
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/phak-vbt6-avex

© Institute of Oriental Manuscripts (Asiatic Museum), Russian Academy of Sciences, 2026
© Group of authors, 2026

IN THIS ISSUE:

On the 60th Anniversary of Ágnes Birtalan 5

PHILOLOGY

Igor A. Alimov. "Dong Jing Meng Hua Lu": The Night Market 8

Serjee Munkhsaikhan. Phonetic Features of Middle Mongolian Consonants: Evidence from Chinese-Transcribed Records 14

Vasiliy Z. Tserenov. Bogdo Mountains in the Caspian Lowland (Variants of a Legend) 21

HISTORIOGRAPHY

Gansukh Enkhtaivan. "The Hoshuu Festival". A Study Comparing the Characteristics of Racehorses in the Painting 26

RELATED DISCIPLINES

Anvarbek M. Mokeev, Kayrat Belek, Nursultan Abdimitalip uulu. The Origins of Asan Kaighy's Philosophy of Compassion 37

Maxim V. Fionin. Margarita M. Elizarova's Manuscript Translation of "The Testament of Abraham": Textual Basis and Translation Strategy 47

ACADEMIC LIFE

Mark A. Kozintcev, Irina V. Kulganek. The Sixth International Academic Conference "The Turko-Mongol World: Past and Present" (St. Petersburg, March 16, 2026) 64

TRANSLATIONS

Regina V. Ivleva. *Sengiin Erdene*. Dsanabadsar (translation from Mongolian, notes) 71

УДК 811.512.3
DOI 10.48612/IVRRAN/u7bg-1hp6-vexm

С. Мөнхсайхан
Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ЗАРИМ ОНЦЛОГ

Түүхэн хэл шинжлэлийн судалгаа нь бидэнд уламжилж ирсэн бичгийн дурсгалуудын ачаар монгол хэл судлалын олон эргэлзээтэй, маргаантай асуудлыг шийдвэрлэн, тэр хэрээр орчин цагийн монгол хэл шинжлэлийн судалгаанд бодитой эх сурвалж, баримт болсоор ирсэн билээ. Гэвч уг судалгаанд нэлээн шийдвэрлэх үүрэгтэй боловч харьцангуй бага судлагдсан нь хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалууд юм. Ялангуяа амьд ярианы хэлэн дэх авианы харилцан нөлөөллийг тэмдэглэсэн байдаг нь авианы хувьсал хөгжлийн түүхэн судалгаанд үнэ цэнэтэй баримт болдог. Бид энэ удаа Монголын нууц товчооны жишээ баримтаар голлон Монгол и юй толь 蒙古譯語 (MY.) /1264/, Хуа и и юй толь 華夷譯語 (Hua.) /1389/, Бэй лу и юй 北虜譯語 (BLY.) /1598/, Лу лун сай люэ-ийн орчуулга үг 盧龍塞畧 (Lu.) /1610/, Бэй лу као 北虜考 /1621/ (BLK) зэрэг дурсгалуудад гарах жишээ баримтаар дэлгэрүүлж, дундад үеийн монгол хэлний гийгүүлэгч авианы зарим онцлогийг тодруулав. Үүнд, дундад үеийн монгол хэлэнд гарсан гийгүүлэгч авиа сулран сугарах, гийгүүлэгч авиа давхарлах зэрэг үзэгдлийг гүнзгийрүүлж судлав. Судалгааны үр дүнд авианы дурдсан үзэгдлүүдийн зарим нь түр зуурын шинжтэй, тухайлбал, хэлэхүйн урсгалд үе төгсгөх гийгүүлэгч авиа гээгдэх үзэгдлийг дурдаж болох ба түүний ул мөр орчин цагийн монгол хэлэнд одоо ч байсаар байна. Мөн хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сулран сугарснаар монгол хэлэнд урт эгшиг үүссэн түүхэн авиа зүйн үзэгдлийн нөлөөгөөр монгол хэлний үгийн бүтцэд зохих өөрчлөлт гарсан байна.

Түлхүүр үг: Дундад үеийн монгол хэл, монгол хэлний хятад үсгийн дурсгал, гийгүүлэгч авиа, гийгүүлэгч авиа сулрах, гийгүүлэгч авиа давхарлах.

Зохиогчийн мэдээлэл: Сэржээгийн Мөнхсайхан, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc. Dr.), дэд профессор (Монгол Улс, Улаанбаатар) (munkhsaikhans@mas.ac.mn).

© Мөнхсайхан С., 2026

Түүхэн хэл шинжлэлийн судалгаа нь бидэнд уламжлан ирсэн бичгийн дурсгалуудын ачаар монгол хэл судлалын олон эргэлзээтэй, маргаантай асуудлыг шийдвэрлэн, тэр хэрээр орчин цагийн монгол хэл шинжлэлийн судалгаанд бодитой үндэс, баримт болсоор ирсэн билээ. Гэвч уг судалгаанд нэлээн шийдвэрлэх үүрэгтэй боловч харьцангуй бага судлагдсан нь хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалууд юм. Уйгуржин болон дөрвөлжин үсгийн дурсгалууд нь дундад үеийн монгол хэлний бичгийн хэлний байдлыг тодруулах боломж олгодог бол хятад үсгийн (мөн араб) дурсгалуудаас тухайн цагийн амьд ярианы хэлний онцлогийг мэдэх боломжтой. Учир нь, хятад үсгийн дурсгалуудын монгол үгийг тэмдэглэсэн галиг нь уйгуржин үсгийн бичгийн тогтолцоонд суурилсан боловч хэлэхүйн урсгал дахь авианы харилцан нөлөөллийг нарийн тодорхой тэмдэглэсэн байдгаараа түүхэн авиа зүйн судалгаанд үнэлж баршгүй ач холбогдолтой юм.

Хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалууд тооны хувьд тийм ч олон биш бөгөөд хэл шинжлэлийн судалгаанд бодитой үндэс, баримт болгон ашиглахад нэлээн баялаг материалтай нь дараах хэдэн сурвалж болно. Үүнд, Монгол и юй толь 蒙古譯語 (MY.) /1264/, Монголын нууц товчоо 元朝秘史 (MNT) /XIV зууны II хагас/, Хуа и и юй толь 華夷譯語 (Hua.) /1389/, Бэй лу и юй 北虜譯語 (BLY.) /1598/, Лу лун сай люэ-ийн орчуулга үг 盧龍塞畧 (Lu.) /1610/, Бэй лу као 北虜考 /1621/ (BLK) юм. Эдгээрт дундад үеийн монгол хэлний олон сонир-

холтой үзэгдэл тэмдэглэгдсэн байх ба энэ удаад зөвхөн гийгүүлэгч авиатай холбоотой зарим баримтыг тодруулан судлав.

Монгол хэлний үгийн хамгийн бага утгат хэсэг нь авиа бөгөөд үг хэлийг дохиожуулах үндсэн үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, хэлний авианы гол шинж нь түүний утга ялгаруулах үүрэг юм. Хэлэхүйн явцад авиа тодорхой цуваанд орж, нэг нэгэндээ харилцан нөлөөлж, зэргэлдээх авианы нөлөөгөөр хэд хэдэн хувилбартай болдог. Авианы байрлалаас шалтгаалж зарим тохиолдолд авиа өөрийн үндсэн шинжээ хадгалж чаддаг бол зарим тохиолдолд үүний эсрэгээр үндсэн шинж нь хувирдаг. Тухайлбал, монгол хэлний тэргүүн үеийн эгшиг авиа ямагт өөрийн үндсэн өнгөө хадгалж, тод сонсогддог. Тэгвэл тэргүүн үеэс хойш орсон эгшиг авиа балархайшдаг, зөөлөн гийгүүлэгчийн орчинд урагшлан хэлэгддэг гэх мэт онцлогтой. Мөн гийгүүлэгч авиа үгийн эхэн, дунд, адагт хаа ч өөрийн үндсэн шинжээ хадгалах боловч үгийн эхэнд орсон чанга гийгүүлэгч дэд үеийн чанга гийгүүлэгчээсээ шалтгаалан амьсгалын түрэлтгүй болох, сул гийгүүлэгч дуугүй болох [Надмид, Санжаа, 1993. Х. 48–49] зэргээр авианы шинж нь хувирдаг ажээ.

ГИЙГҮҮЛЭГЧ АВИА СУЛРАН СУГАРАХ. Монгол хэлний хятад үсгийн дурсгалуудад тэмдэглэгдсэн гийгүүлэгч авиатай холбоотой олон үзэгдэл нь монгол хэлний гийгүүлэгч авианы ерөнхий тогтолцоог гаргахад чухал баримт хангадаг. Хэдийгээр монгол хэлний гийгүүлэгч авиа нь монгол хэлний урт удаан түүхэн хөгжлийн явцад хэлэгдэх онцлогоо харьцангуй хадгалсаар ирсэн боловч хэлний хэмнэх зарчим болоод өгүүлэхүйн эрхтний энерги арвилах шаардлагаар зарим авиа гээгдэн сугарч, зарим нь зэргэлдээх авианы нөлөөгөөр утга ялган, шинээр нэмэгдэх зэргээр үргэлжийн хөгжил хөдөлгөөнд байжээ. Авиа сулрах үзэгдэл нь авианы харилцан бие биедээ нөлөөлөх түгээмэл хуулийн дагуу зэргэлдээ авианыхаа давамгайлах нөлөөн дор явагддаг. Гийгүүлэгч авиа ингэж сулрах явцдаа хамжихаас шүргэх, шүргэхээс сул шүргэх зэргээр өгүүлэгдэх хам шинжээ алдсаар эцсийн эцэст фонем (авиалбар), морфем (бүтээвэр)-ийнхоо үүргийг бүрмөсөн алдан сулран сугардаг [Төмөртогоо, 2017в. Х. 298] байна. Бидний судалгаанаас үзвэл, уг үзэгдлийн үйл явц, үр дүн нь үе төгсгөх болон үгийн дундах гийгүүлэгчдэд харилцан адилгүй байна.

А. Үе төгсгөх гийгүүлэгч авианы сулрал. Монгол хэл залгамал бүтэцтэй, тодорхой байрлал бүхий бүтээврүүдийг угсруулан залгаж үг бүтээдэг онцлогтой. Монгол хэлний үеийн бүтэц, хувьслыг судалсан эрдэмтдийн үзэхээр монгол хэлний үе эгшиг, гийгүүлэгч хоёроос бүтэж, авианы тодорхой дараалал бүхий V, VC, CV, CVC [Төмөртогоо, 2017в. Х. 326–335] гэсэн бүтэцтэй гэжээ. Үүнээс VC, CVC бүтцийн төгсгөлд тохиолдох гийгүүлэгчийг “үе төгсгөх” гийгүүлэгч гэх агаад уйгуржин монгол бичгийн хэлэнд “дэвсгэр” гийгүүлэгч хэмээн нэрлэдэг. Монгол хэлний хятад үсгийн дурсгалуудад тэмдэглэгдсэн гийгүүлэгч авиатай холбоотой үзэгдлүүдээс хамгийн сонирхолтой нь хэлэхүйн урсгалд үе төгсгөх гийгүүлэгч авиа суларч буй үзэгдэл юм. Үүнд, үе төгсгөх гийгүүлэгчээр төгссөн үгэнд эгшгээр эхэлсэн дагавар залгахад үгийн эцсийн гийгүүлэгчийн авианы шинж хувирна. Жишээ нь,

q>g :

MNT. turqaq→turqag-i

MNT. uruq→urug-i, urug-iyan,urug-iyar

MNT. nuntuq→nuntug-iyan

MNT. omoq→omog-iyan

MNT. ǰarliq→ǰarlig-iyar

MNT. quyaq→ quyag-iyan

Энэ тохиолдолд i-ээр эхэлсэн нөхцөл залгахад өмнөх q гийгүүлэгч сулран урагшилж g болжээ. Өөр нөхцөл залгавал авианы шинжээ тогтвортой хадгалж байна. Жишээ нь,

nuntuq→nuntuq-ača, nuntuq-tur, nuntuq-ṭur

ǰarliq→ǰarliq-tur, ǰarliq-un

гэх мэт.

q>k :

MNT. ayimaq→ayimak-iyar-iyan,

MNT. tuq→tuk-iyan

MNT. uruq→uruk-iyar-iyan

Жишээнээс үзвэл зөвхөн i эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад q гийгүүлэгчийн (хэлний гүн угаар хэлэгддэг) авианы шинж хувирч байна. Энэ нь угтаа эр үгэнд ордог уул k гийгүүлэгч нь i эгшгийн өмнөх *q-аас үүссэнийг баталж байна. Өөр бусад нөхцөл залгавал

MNT. ayimaq→ayimaq-un

MNT. uruq→ uruq-a, uruq-ača, uruq-tur, uruq-un

гэх мэтээр авианы шинжээ хадгалдаг ажээ. Дурдсан хоёр авианы үзэгдэл нь угтаа i-гийн өмнөх q гийгүүлэгчийн тагнайших үйл явц бөгөөд тодруулбал, q нь тагнайшихаас өмнө суларч q→g→k болсны баримт юм.

k>g :

MNT. ǰük→ǰüg-eče, ǰüg-ün

MNT. kerek→kereg-iyen

MNT. kešik→kešig-eče, kešig-ün

MNT. čerik→čerig-eče,čerig-iyen, čerig-iyer, čerig-ün

MNT. ök-→ ögü'et, ögüle'e, ögümü, ögün, ögüre, ögürün

MNT. külük→külüg-i, külüg-iyer, külüg-ün

MNT. esük→esüg-iyen

MNT. temdek→temteg-ün

Зөвхөн эм үгэнд тохиолддог хэлний хойгуурх, дуугүй, хамжих k нь эгшгээр эхэлсэн нөхцөл (-eče, -i, -iyer, -ün) залгавал дуутай, хамжих g болж байна. Харин гийгүүлэгчээр эхэлсэн нөхцөл залгавал k нь авианы үндсэн шинжээ хадгалж, хатуу дэвсгэр учир -tür/-ṭür нөхцөлийг залгаж байна. Жишээ нь,

MNT. ǰük→ǰük-tür, ǰük-ṭür

MNT. kešik→kešik-ṭür гэх мэт.

t(дэвсгэр d)>d:

MNT. noyat→noyad-ača, noyad-i, noyad-un

MNT. önečit→önečid-ün

MNT. minqat→minqad-ača, minqad-un

MNT. morit→morid-iyan

MNT. müret→müred-ün

MNT. ökit→ökid-i, ökid-iyen, ökid-ü'en

Монголын нууц товчоонд ижил цаг үед хамаарах уйгуржин бичгийн дурсгалуудад хэвшиж амжаагүй байсан дэвсгэр гийгүүлэгчдийг ялган тэмдэглэх зарчим маш тодорхой үйлчилдэг. Үүнд дэвсгэр d гийгүүлэгчийг t-ээр тэмдэглэсэн ба энэ нь нэг талаар дэвсгэр гийгүүлэгчийг дэвсгэрлэдэггүй гийгүүлэгчээс ялгасан мэт боловч авианы үзэгдлийн талаас авч үзвэл хэлэхүйн урсгалд авианы харилцан нөлөөллийн үр дүнг тусгасан байна.

s>*š*: MNT. *nudurqas →nudurqaš-iyan

Авианы уг үзэгдлийг Монголын нууц товчооны хятад галигт маш тодорхой тэмдэглэсэн боловч латин галиг боловсруулагсад "нударгас" гэдэг үгээс бусдыг нь s авиагаар тэмдэглэжээ. Учир нь, Монголын нууц товчооны галигийг бичгийн хэлний галиг хэмээн үзсэнтэй холбоотой. Гэвч

noqa-‹i›s 那中孩思>noqas-iyan 那中合**昔**顏 (noqaš-iyan)

*yaras 牙舌剌**思**>yaras-iyan 牙舌剌**昔**┌ (yaraš-iyan)

*se'üses 薛兀薛**思** > se'üses-i 薛兀薛**昔** (se'üseš-i)

*tusas 土撒**思**>tusas-i土撒**昔** (tusaš-i)

aqtas 阿黑騧**思** [阿黑騧思]>aqtas-iyan 阿黑騧**昔**顏 (aqtaš-iyan)

*geriyes 格舌里耶**思**>geriyes-iyen 格舌里耶**昔**顏 (geriyeš-iyen)

ečiges 額赤格**思**>ečiges-i 額赤格**昔** (ečigeš-i)

beyes 別耶**思** [別耶思]>beyes-iyen 別耶**昔**顏 (beyeš-iyen)

гэх мэт үгийн хятад галигаас үзвэл, s авианы араас i авиа орсон тохиолдолд бүгд хэлний үзүүр, тагнайн шүргэх š болсон байна.

Монголын нууц товчооны жишээ баримтаас үзвэл, энэ үед s, š бүрэн ялгарч, утга ялгадаг болсон байна. Тухайлбал,

үгийн эхэнд: šibawulan, šidü, šibe'e, šira

үгийн дунд: tušiyaldun, kešik, qaši'un

гэх мэтээр уул үзэгдлийг тэмдэглэжээ.

Б. Үгийн дундах гийгүүлэгч авианы сулрал. Дундад үеийн монгол хэлний хоёр эгшгийн дундах шүргэх гийгүүлэгчийн тухай гадаад дотоодын олон эрдэмтэн тусгайлан судалж, хоёр эгшгийн арын эгшиг уртаар дуудагдаж байсантай холбоотойгоор өмнөх гийгүүлэгч сулран, улмаар гээгдсэн гэсэн дүгнэлтэд хүрчээ [Төмөртогоо, 2017б. Х. 233–235]. Үүнийг батлах баримт нь Монголын нууц товчоо болон хятад үсгийн бусад дурсгалд тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд үгийн дундах гийгүүлэгч авиа сулран сугарснаар монгол хэлэнд урт эгшиг үүссэн байна. Үүнийг үзүүлбэл:

1/ Юуны өмнө уйгуржин монгол бичигт тэмдэглэгдсэн Vq(γ)/gV бүтэцтэй урт эгшгийн дундах гийгүүлэгч арын эгшгийн хэлэгдэх онцлогоос шалтгаалан суларч төвөнхийн шүргэх h болж, улмаар сугарсан. Жишээ нь,

qahan 中合罕>qa'an-a 中合阿納 “*хаан*”
güǰühün 古主渾[1]>güǰü'ün 古主温 “*хүзүү*”

2/ Мөн хоёр эгшгийн арын уруулын эгшгийн нөлөөгөөр дундах шүргэх гийгүүлэгч нь сулрах явцдаа уруулын эгшгийн хэлэгдэх байдалд татагдан уруулын шүргэх w болж, улмаар бүрмөсөн сугарсан. Жишээ нь,

Мб. baqu->MNT. bawu- →ba'u- “*буух*”
Мб. bidaqu>MNT. budawu “*бядуу*”
Мб. čegülün>MNT. čewülün “*цүүлэн*”
Мб. daqun>MNT. dawun → da'un “*дуун*”
Мб. daquli->MNT. dawuli- → da'uli-→dauli “*дайлах*”
Мб. maqun>MNT. mawun “*муу*”
Мб. negU->MNT. newü- “*нүүх*”

3/ Хоёр эгшгийн дундах гийгүүлэгч бүрмөсөн сугарч амьсгалын түрэлтээр зааглагдсан. Жишээ нь, qa'alqa, ü'ürčü, ine'ebe гэх мэт.

4/ Хэрэв амьсгалын түрэлтээр зааглагдсан хоёр эгшиг ижил байвал qālqa, ūrčü, inēǰü'ü гэх мэтээр урт болсон.

5/ Хэрэв амьсгалын түрэлтээр зааглагдсан хоёр эгшиг өөр байвал эхлээд амьсгалын түрэлтийн арын уруулын эгшиг өмнөх уруулын бус эгшгээ уруулшуулж, улмаар амьсгалын түрэлт үгүй болоход өөртөө бүрэн ижилсүүлсэн. Жишээ нь,

nau'ur 恼兀兒 “*нуур*”
au'ula 襖兀剌 “*уул*”
čilau'un 赤老文 “*чулуун*”
deü'ü 斗兀 “*дүү*”
ǰeü'ü 呪兀 “*зүү*”

гэх мэт. Энэ үзэгдэл Дэн тан би жю-ийн 20-р боть болох Бэй лу и юй /1598/-д, мөн Лу лун сай люэ-ийн 19, 20-р бүлгийн орчуулгын бүлэг [1610]-т тус тус тэмдэглэгджээ.

6/ Зарим тохиолдолд амьсгалын түрэлт үгүй болоход хоёр эгшиг (хоёр өөр) аль алинтайгаа ижилсэлгүй нийлсэн. Жишээ нь, dauli-, niuča гэх мэт авианы үйл явц болжээ.

Энэ мэтчилэн уртаар дуудагддаг хэл зүйн нөхцөлүүдийн үгийн дундах гийгүүлэгч авиа мөн сулран сугарсан. Жишээ нь,

baralu'a 巴舌剌魯阿 “*барлаа*”
čewürelü'e 潮兀舌列魯阿 “*цүүрлээ*”
bari'at 把舌里阿楊 “*бариад*”
bariǰu'ui 把舌里主為 “*барьжухуй*”
bariqsa'ar 把舌里黑撒阿舌児 “*барьсаар*”
bari'ulu'at 把舌里兀魯阿楊 “*бариулаад*”
berile'ülǰü 別舌里列兀勒周 “*бэрлүүлж*”

-Монголын нууц товчооны жишээнээс үзвэл үгийн дундах b гийгүүлэгч сугарсан тохиолдлын олонх нь хэл зүйн нөхцөл дээр илэрч байна. Жишээ нь,

-Уйгуржин монгол бичгийн үйлийн холбох нөхцөл -basu/-besü

irebesü 亦舌列別速>ire'esü
亦舌列阿速 “*ирвээс*”
quyubasu 中忽余巴速>
quyu'asu 中忽余阿速 “*гуйваас*”
üǰebesü 兀者別速>üǰe'esü
兀者額速 “*үзвээс*”
yabubasu 迓步巴速>
yabu'asu 迓步阿速 “*явбаас*”

-Үйлдэхийн тийн ялгалын -bar/-ber

gerü-ber 格舌魯別舌児>
gerü-er 格[舌]魯額舌児 “*хэрүүгээр*”
miqa-bar 米中合巴舌児>
miqa-ar 米中合阿舌児 “*махаар*”
öngge-ber 汪格別児>
öngge-er 汪格額舌児 “*өнгөөр*”
elbesü-er 額勒別速額舌児 “*элбэсээр*”
ǰayā-ar 札牙阿舌児 “*заяагаар*”
qaqča-ar 中合黑察阿児 “*гагцаар*”

-Нэрийн хамаатуулах нөхцөл -ban/-ben

qo'olai-da-an 中豁斡来荅安 “*хоолойдоо*”
inǰes-eče-en 勝哲薛扯延 “*инжсээсээ*”
nidün-eče-en 你覩捏扯延 “*нүднээсээ*”
egeči-de-en 額格赤迭延 “*эгчдээ*”

гэх мэт жишээ байна.

ГИЙГҮҮЛЭГЧ АВИА ГЭЭГДЭХ. Дундад үеийн монгол хэлэнд нэлээн түгээмэл байсан авианы үзэгдлийн нэг нь үе төгсгөх гийгүүлэгч гээгдэх явдал юм. Уул үзэгдэлд хэлний хэмнэх зарчим нэлээн нөлөөлсөн бололтой байна. Монгол хэлний хятад үсгийн дурсгалуудад үе төгсгөх гийгүүлэгч авиа сугарсан жишээ олон тааралддаг. Жишээ нь, Монгол и юй тольд

	Хятад орчуулга	Хятад галиг	Латин галиг
虎	八索		ba(r)so /барс/
鉄	忒木真		temü(r)ǰin /төмөрчин/

[1] Түүхэн хэл зүйн баримтаас үзвэл γ/g-ийн арын эгшиг нь a, э байвал энэ үзэгдэл болдог ба хэрэв уруулын эгшиг байвал дундах гийгүүлэгч нь уруулын шүргэх w болдог. Гэвч Монголын нууц товчоонд уруулын эгшгийн дундах гийгүүлэгч сул шүргэх h болсон жишээ байна.

筋	秀布	šü(r)bü(sü) /шөрмөс/
海東青	剌速忽兒	ǰala su(ng)qur /шонхор/
花馬	阿剌	ala(q) (mori)
甲	忽耶	quye(q) /хуяг/
花	掣掣	čeče(k)
文書	必赤	biči(k)
红	忽剌	hula(n)
藍	怒窩	nu’o(n) /ногоо/
珠子	速不	subu(d)
韮	和和	qoqo(d)
跋	朶忽剌	doqula(ng)
孔雀	倒虎	dauqu(s) /тогос/

Түүхэн авиа зүйн үүднээс үзвэл гийгүүлэгч авиа суларсны үр дүнд бүрмөсөн сугардаг зүй тогтолтой. Харин үе төгсгөх гийгүүлэгч авиа ийнхүү шууд гээгдсэн баримтыг дундад үеийн монгол хэлэнд байсан, одоо ч орчин цагийн монгол хэлэнд байгаа тогтворгүй “n”-тэй холбоотой авианы үзэгдэлтэй адилтган үзэж болох бөгөөд тодруулбал, дундад үеийн монгол хэлэнд үе төгсгөж буй гийгүүлэгч, ялангуяа үгийн төгсгөлийн гийгүүлэгч авиа олонхдоо тогтворгүй байж хэлэхүйн урсгалд гээгддэг байсны баримт хэмээн үзэв. Өөрөөр хэлбэл, ингэж үе төгсгөх гийгүүлэгч тогтворгүй хэлэгддэг авианы үзэгдэл нь түр зуурын шинжтэй байсан, ялангуяа дундад үеийн монгол хэлэнд нэн идэвхтэй илэрч байсан бөгөөд эдүгээ уул үзэгдлийн ул мөр нь монгол хэлний харьяалах, өгөх орших, гарахын тийн ялгалын нөхцөлийг нэр үндсэнд залгахад илэрдэг авианы үзэгдлээр илэрч байж болно. Орчин цагт дурдсан гийгүүлэгч авианууд аас зөвхөн “n”-тэй холбоотой авианы үзэгдэл хадгалагдан үлджээ.

Үүнээс гадна нэр үгэнд хэл зүйн нөхцөл залгах үед үе төгсгөх гийгүүлэгч сугарна. Үүнд:

-Ye төгсгөх гийгүүлэгчийн араас нэрийн олон тооны -ud/-üd нөхцөл залгавал үгийн эцсийн гийгүүлэгч сугарна. Жишээ нь, Монголын нууц товчоонд:

ayimaq→ayima’ud-ača

uruq→uru’ud- ača

turqaq→turqa’ut, turqa’ut-lu’a,

turqa’ud-i, turqa’ud-iyan, turqa’ud-iyar, turqa’ud-un

kešik→keši’üt/ keši’üd-ün

külük→külü’üt/külü’üd-i, külü’üd-iyen, külü’üd-iyer-iyen, külü’üd-ün

čerik→čeri’üt, čeri’üt-lü’e-ben, čeri’üt-te, čeri’üt-tür, čeri’üt-ṭür

čeri’üd-i, čeri’üd-iyen, čeri’üd-iyer, čeri’üd-ün

esük→esü’üt

Жич: энэ тохиолдолд урт эгшиг үүсэх үйл явц /Vq(γ)/gV>V’V/-тай адил авианы орчин бүрдсэн учир ийнхүү үгийн эцсийн гийгүүлэгч сугарсан байна. Жишээ нь,

qa’alqa, ü’ürčü, ine’ebe=turqa’ut, külü’üt, esü’üt

гэж үзэж болно. Гэвч өнгөц харахад үе төгсгөх k, q гийгүүлэгч сугарсан мэт боловч, эдгээр хамжих гийгүүлэгч хэлэхүйн урсгалд шууд гээгддэггүй тул суларч k>g, q>g>k болсны үр дүнд сугарсан байна. Жишээ нь, čerik>čerig-eče, čerig-iyen, turqaq>turqag-i гэх мэт.

-Ye төгсгөх гийгүүлэгч авианы араас тийн ялгалын нөхцөл залгавал үгийн эцсийн гийгүүлэгч сугарна. Жишээ нь, Монголын нууц товчоонд,

aldal>alda[l]-ṭur [205§]

güreget>gürege[t]-te [66§, 120§]

*geyit>geyi[t]-tür-iyen [134§]

nököt>nökö[t]-de-en [170§]

učumaq-ār /208§/>učuma-ar [174§]

гэх мэт.

-Мөн үе төгсгөх гийгүүлэгчээр төгссөн үгэнд шинэ үг бүтээх дагавар залгавал гээгдэнэ. Жишээ нь Монголын нууц товчоонд, boro[q]čin /25§/, dayyiǰi[q]či /105§/, helige[b]čitü /135§/, ono[b]či /178§/, hüke[r]čin /234§/, manaqa[r]ši /66§/ гэх мэт, мөн Монгол и юй толийн өмнөх жишээг үүнд оруулж болно.

Хэдийгээр ярианы урсгалд үе төгсгөх гийгүүлэгч гээгдэх үзэгдэл нь дундад үеийн монгол хэлэнд гарсан түр зуурын шинжтэй үзэгдэл боловч орчин цагт зарим нутгийн аялгуунд (тухайлбал, ойрад) дээрх үзэгдэл хадгалагдан үлдсэн жишээ цөөнгүй тааралддаг.

ГИЙГҮҮЛЭГЧДАВХАРЛАХ. Дундад үеийн монгол хэлний гийгүүлэгч авиатай холбоотой өөр нэг үзэгдэл бол гийгүүлэгч давхарлах юм. Энэ нь авианы харилцан нөлөөллийн хүрээнд авиа ижилших хандлагын үр дүнд үүссэн зүй тогтол [Төмөртогоо, 2017a. Х. 236–238] бөгөөд давхарлан гарч ирсэн гийгүүлэгч нь утга ялгах

үүрэггүй зөвхөн ярианы хэлэнд тохиолддог үзэгдэл юм. Жишээ нь,

n гийгүүлэгч: MNT. qun-nu, qurban-ni, šinggeksen-nü

MY. onnu (腕奴) “онь”,

Lu. fula’anne (伏剌案捏) “улаагана”

Lu. ba’anna (八按納) “багана”

m гийгүүлэгч: MY. gülimma (骨林馬) “гөлөм”,

MY. tamme (探麥) “тэмээ”

t (дэвсгэр d) гийгүүлэгч: erdemütten (額舌児迭木惕田)

doroyitda’ulǰu (朶舌羅亦惕荅兀勒周)

gene[t]te (格捏帖)

güreget-te (古舌列格惕帖)/ güriget-te (古舌里格惕帖)

čeri’üt-te (扯舌里兀惕帖)

kö’üt-te (可兀惕帖)

minqat-ta (敏中合惕塔)

noyat-ta (那牙惕塔)

ündüt-te (温都惕帖)

qaldut-ta (中合勒都惕塔)

yabulduqsat-ta (迂步勒都黒撒惕塔) гэх мэт.

Гийгүүлэгч давхарлах нь дундад үеийн монгол хэл төдийгүй орчин цагийн монгол хэлэнд ч байгаа үзэгдэл билээ. Ярианы хэлэнд гийгүүлэгчийн араас эгшиг орвол бараг бүх гийгүүлэгч давхарлан хэлэгддэг онцлогтой. Жишээ нь, allaɣ “*алаг*”, xīxxēr “*хийхээр*”, attar “*атар*”, qarrā “*хараа*”, awwād “*аваад*” гэх мэт. Тэгвэл дундад үеийн монгол хэлний гийгүүлэгч давхарлах үзэгдэлтэй холбоотой онцлон дурдах зүйл нь уул үзэгдлийн нөлөөгөөр монгол хэлний өгөх оршихын тийн ялгалын -da/-ta, -de/-te хувилбар үүссэн [Мөнхсайхан, 2022. Х. 102–109] болохыг харж болно. Тухайлбал,

čeri’üt+e=čeri’üt-**t**e

kö’üt+e=kö’üt-**t**e

qaldut+a=qaldut-**t**a

noyat+a=noyat-**t**a

болсон буюу энэ нь угтаа үе төгсгөх гийгүүлэгчийн араас эгшгээр эхэлсэн дагавар залгахад үе төгсгөх гийгүүлэгч давхарлан хэлэгддэг авианы харилцан нөлөөллийг тэмдэглэсэн хэрэг юм. Иймээс өгөх оршихын тийн ялгал нь үндсэн -a/-e, -tur/-tür, -dur/-dür гэсэн нөхцөлтэй бөгөөд ярианы хэлэнд гийгүүлэгч давхарлах үзэгдлийн нөлөөгөөр -da/-ta, -de/-te хувилбар, өмнө дурдсан үе төгсгөх гийгүүлэгч гээгдэх үзэгдлийн нөлөөгөөр -du/-dü, -tu/-tü гэсэн хувилбарууд нэмэгдэж

-a/-e, -da/-ta, -de/-te

-tur/-tür, -dur/-dür, -du/-dü, -tu/-tü

гэсэн олон хувилбартай болсон байна. Үүнд -du/-dü, -tu/-tü хувилбар нь Монголын нууц товчоонд байдаггүй тул Монголын нууц товчооноос хойш үүссэн гэж үзэж болно. Үүнээс үзвэл дундад үеийн монгол ярианы хэлэнд өгөх оршихын тийн ялгалын

-a/-e, -da/-ta, -de/-te

-tur/-tür, -dur/-dür, -ṭur/-ṭür

гэсэн хувилбарууд байжээ. Гэвч монгол хэлний түүхэн хөгжлийн явцад ярианы хэлний нөлөөгөөр үүссэн -da/-ta, -de/-te хувилбар нь орчин цагт бичгийн хэл болоод бичгийн хэлний суурь аялгуунд үгүй болж, зөвхөн монгол төрөл хэл болоод зарим нутгийн аялгуунд хадгалагдан үлджээ. Ийнхүү дундад үеийн монгол хэлэнд ярианы хэлний нөлөөгөөр өгөх оршихын тийн ялгал нь олон тооны хувилбартай болж олширч байсан бол, орчин цагт ердөө -a/-e, -d/-t гэсэн хувилбартай болсон нь уул нөхцөлүүд хэлний хэмнэх зарчмын нөлөөгөөр хэмнэгдэн хураагдсан болохыг харуулж байна.

Дүгнэлт: Судалгаанаас үзвэл, дундад үеийн монгол хэлэнд гийгүүлэгч сулрах үзэгдэл тун идэвхтэй илэрч байсан ба уул үзэгдлийн нөлөөгөөр үүссэн авианы зарим үзэгдэл нь түр зуурын шинжтэй байсан бол (үе төгсгөх гийгүүлэгчтэй холбоотой) зарим нь монгол хэлний үгийн бүтэц, хэлбэрийг үндсээр өөрчилсөн түүхэн авиа зүйн үзэгдэл байв. Тухайлбал, хоёр эгшгийн дундах гийгүүлэгч авиа сулран сугарснаар монгол хэлэнд урт эгшиг үүссэн байна. Гийгүүлэгч авиа ингэж сулрахад арын эгшгийн уртаар дуудагдаж байсан авианы шинж нөлөөлснийг хэлний олон баримт нотолж байна. Энэ мэт жишээ баримтаас үзвэл, дундад үеийн монгол хэлэнд гийгүүлэгч сулрах үзэгдэл давамгайлж байсан бол орчин цагийн монгол хэлэнд эгшиг балархайших хандлага илүү ажиглагдаж байгаа ажээ.

Ашигласан ном зүй

Мөнхсайхан, 2020: *Мөнхсайхан С.* Монголын нууц товчооны тонгоруу толь. Соёмбо принтинг хэвлэлийн компани. Улаанбаатар, 2020.

Мөнхсайхан, 2022: *Мөнхсайхан С.* Монголын нууц товчоонд гийгүүлэгч давхарлахын учир // ALTAICA XVIII, Соёмбо принтинг хэвлэлийн компани. Улаанбаатар, 2022.

Надмид, Санжаа, 1993: *Надмид Ж., Санжаа Ж.* Орчин цагийн монгол хэлний авиа зүй. Улаанбаатар, 1993.

Төмөртогоо, 2017а: *Төмөртогоо Д.* Дундад үеийн монгол хэлний гийгүүлэгч давхарлах ёс (Дундад үеийн монгол хэлний жишээгээр) // Монгол хэлний түүхэн хэл шинжлэлийн судалгаа. Улаанбаатар, 2017.

Төмөртогоо, 2017б: Дундад үеийн монгол хэлний хоёр эгшгийн хоорондох шүргэх гийгүүлэгчийн сулрал // Монгол хэлний түүхэн хэл шинжлэлийн судалгаа. Улаанбаатар, 2017.

Төмөртогоо, 2017в: *Төмөртогоо Д.* Үеийн бүтэц, хувьсал // Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс. Соёмбо принтинг хэвлэлийн компани. Улаанбаатар, 2017.

PHONETIC FEATURES OF MIDDLE MONGOLIAN CONSONANTS: EVIDENCE FROM CHINESE-TRANSCRIBED RECORDS

Serjee Munkhsaikhan
Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences

Historical linguistic studies have been solving ambiguous and debated issues of Mongolian language studies with the help of the written records that have been passed down to us, providing solid evidence to contemporary Mongolian studies. However, the Mongolian language records, which were noted in Chinese characters, are the part that has a crucial role but has been studied relatively less. In particular, the documentation of phonetic dynamics within live spoken language serves as invaluable evidence for the study of historical phonological evolution. In this article, certain features of Middle Mongolian consonants were examined, primarily utilizing examples from The Secret History of the Mongols. These findings were further corroborated by data from historical sources including Mongol yi yu 蒙古譯語 (MY.) /1264/, Hua yi yi yu 華夷譯語 (Hua.) /1389/, Bei lu yi yu 北虜譯語 (BLY.) /1598/, Lu long sai lue 盧龍塞畧 (Lu.) /1610/, and Bei lu kao 北虜考 (BLK) /1621/. From these, an in-depth investigation was conducted into phenomena such as the weakening and elision of consonants, as well as consonant gemination, occurring in Middle Mongolian. Research results indicate that some of these phonetic phenomena were transitory; specifically, the elision of syllable-final consonants within the flow of speech was identified, the traces of which remain present in modern Mongolian. Furthermore, the formation of long vowels — resulting from the weakening and loss of intervocalic consonants — is recognized as a historical phonetic development that led to corresponding structural changes in Mongolian words.

Key words: Middle Mongolian, Chinese-transcribed Mongolian texts, consonants, consonant weakening, consonant gemination.

About the author: **Serjee Munkhsaikhan**, Sc. Dr., Assistant Professor, Leading Researcher at the Department of Linguistics, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (munkhsaikhans@mas.ac.mn).